



22

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/11

Эрдэнэт


2022 оны цанын өсвөр үеийн Төвийн
бүсийн аварга шалгаруулах тэмцээнд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Төв аймгийн Борнуур суманд 2022 оны 01 дүгээр сарын 23-26-ны өдрүүдэд зохиогдсон 2022 оны цанын өсвөр үеийн Төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаас оролцсон 13 хүний байр, хоол, замын зардалд 991,500 (есөн зуун ерэн нэгэн мянга таван зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Тэмцээний зардал 991,500 (есөн зуун ерэн нэгэн мянга таван зуу) төгрөгийг зохих журмын дагуу уралдаан, тэмцээний зардалаас гаргаж, аймгийн “Ирээдүйн Хос мөртөн” цанын холбооны дансанд шилжүүлэхийг нягтлан бодогч (Б.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.ДЭЛГЭРБАЯР



Биеийн тамир, Спортын газрын даргын
2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
10/11 дугаар тушаалын хавсралт



2022 ОНЫ ЦАНЫН ӨСВӨР ҮЕИЙН ТӨВИЙН БҮСИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ
ТӨСВИЙН ЗАДАРГАА

1.Замын зардалд /ирэх, очих шатахуун/:

1 талдаа 300км-2 талдаа 600 км, дотор үйлчилгээнд-150км явах,
/100км-д 20 л/

120л x 2,350 төгрөг = 282,000төгрөг,

30л x 2,350 төгрөг = 70,500 төгрөг,

Тосол, масло 1ш x 15,000 төгрөг = 20,000 төгрөг

1ш x 14,000 төгрөг = 19,000 төгрөг

2.Байр 10 хүн x 3 хоног x 8,000 төгрөг = 240,000 төгрөг

3.Хоол 10 хүн x 3 хоног x 8,000 төгрөг = 240,000 төгрөг

4.Дасгалжуулагч багш, жолооч:

хоол- 2 хүн x 3 хоног x 12,000=72,000 төгрөг

байр - 2 хүн x 2 хоног x 12,000= 48,000 төгрөг

Төсвийн нийт дүн: 991,500 төгрөг

---oOo---